



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024. 02. 19.

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “ Э-Транс Ложистикс “ ХК-ны 2023 оны татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6 төгрөгөөр тооцон 46,200,000 хувьцаанд нийт 277,200,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2024 оны 12 сарын 31-ний дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Энхболдод даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД